

ДОТООДЫН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ



2025.04.07

Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- 3-р сард ТОП-20 индекс 603 тэрбумын үнэлгээгээ алдлаа.
- ХК-иудын ногдол ашгийн бүртгэлийн өдөр дуусч байна.
- Хас банк 3.5 тэрбум төгрөгөөр хувьцаагаа буцаан худалдаж авна.
- Ам.долларын ханш 3,500-г давлаа

МХБ-ийн индексийн өгөөж

| Индекс | Долоо хоног | Сар | Жил |
|-------------------------|-------------|--------|--------|
| ТОП 20 | -2.83% | -4.31% | 25.47% |
| MSE A | -6.78% | -4.66% | 20.27% |
| MSE B | -1.41% | -4.62% | 34.89% |
| 2025/03/31 – 2025/04/04 | | | |

Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

| Симбол | Үнийн дүн |
|-------------------------|------------------|
| QPAY | 6,087,502,729.12 |
| KHAN | 2,681,744,291.00 |
| TTL | 431,150,240.00 |
| CUMN | 339,353,987.21 |
| MSE | 317,113,492.05 |
| 2025/03/31 – 2025/04/04 | |

Өндөр өсөлттэй үнэт цаас

| Симбол | Хаалтын ханш | Өсөлт % |
|-------------------------|--------------|---------|
| SOR | 7,300.00 | 26.96% |
| ONH | 19,550.00 | 15.00% |
| MSH | 293.00 | 14.90% |
| MRX | 27.00 | 14.55% |
| UNS | 12,100.00 | 14.15% |
| 2025/03/31 – 2025/04/04 | | |

2025 он 04-р сарын 07

Зах зээлийн
үнэлгээ тэрбум ₮

12,086

ТОП-20 индекс

48,519

MSE A

18,148

MSE B

14,500



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

4.9%

2024 он

Инфляц

9.6%

2025-02 сар

ГВУН(сая\$)

4,995.97

2025-03 сар

Бодлогын

хүү

12.0%

ЗГ-ын бондын
өгөөж

8.5%

USD/MNT

3,505.87

2025-04-06




Эдийн засгийн мэдээлэл

АМ.ДОЛЛАРЫН ХАНШ 3,500-Г ДАХИН ДАВЛАА




Дональд Трампын шинэ тарифын бодлоготой холбоотойгоор ам.долларын ханшийн индекс сүүлийн 2.5 жилийн доод түвшинд хүрч, хөгжиж буй орнуудын валютууд чангарлаа. Харин төгрөг ам.долларын эсрэг гурав дахь өдрөө дараалан суларч, 2023 оноос хойш анх удаа 3500 нэгжээс давлаа. Үүнээс гадна, Монгол Улсын 2025 оны эхний хоёр сарын төлбөрийн тэнцэл 742.2 сая ам.долларын алдагдалтай гарсан нь өмнөх оны ашигтай үзүүлэлтээс эрс дордсон байна.



ТОП-20 ИНДЕКС 3-Р САРД ХҮЧТЭЙ УНАЛАА

ТОП-20 индекс өнгөрсөн 3-р сард 4.31 хувиар унасан бөгөөд энэ 4-р сард ч гэсэн уналт үргэлжилнэ. Учир нь ХК-иудын ногдол ашгийн бүртгэлийн өдрүүд 3,4-р саруудад болдог юм. Иймээс түүхэн статистикаас харахад ч гэсэн хамгийн өндөр уналттай байдаг үе нь 3,4-р сарууд.





Дотоодын зах зээлийн мэдээлэл

ББСБ-ЫН САЛБАРЫН АКТИВ ДНБ-ИЙ 8.9%-ТАЙ ТЭНЦЭЖ БАЙНА



Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2024 онд урьдчилсан гүйцэтгэлээр 80.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 9.5 их наяд төгрөг буюу 13.5 хувиар өссөн талаар Үндэсний статистикийн хороо мэдээллээ.

ДНБ-ий өсөлтөд уул уурхай, олборлолтын салбар болон үйлчилгээний салбарын өсөлт голлон нөлөөлсөн байна.

- Уул уурхайн салбарын нэмэгдэл өртөг 2.0 их наяд төгрөгөөр (10.0%) нэмэгдсэн,
- Үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 6.4 их наяд төгрөгөөр (22.2%) өссөн нь эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгөгч хүч болсон байна.

Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад багтах хөрөнгийн зах зээл, даатгалын салбар, банк бус санхүүгийн байгууллага (ББСБ), хадгаламж, зээлийн хоршоод нь ДНБ-ий 26.5 хувийг бүрдүүлж, өмнөх оноос 1.6 хувиар нэмэгджээ.

ХАС БАНК 3.5 ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР ХУВЬЦААГАА БУЦААН ХУДАЛДАН АВАХААР БОЛЛОО

2025 оны 4-р сарын 4-ний өглөө – [MSE:XAC] Хас банк ХК хөрөнгийн зах зээл дээрээс нийт 3.5 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 4.0 сая ширхэг хүртэлх хувьцаагаа буцаан худалдан авч, дахин халааслах (buyback) шийдвэрээ албан ёсоор зарлалаа.

Худалдан авалтын гол нөхцөлүүд:

- Хугацаа: 6 сар
- Дээд хэмжээ: 4.0 сая ширхэг хувьцаа
- Нийт зардал: 3.5 тэрбум төгрөг
- Нэгж хувьцааны дээд үнэ: 888.0 төгрөг

Өмнөх buyback түүх:

Хас банк өмнө нь 2024 оны 11-р сард ч мөн ижил төстэй шийдвэр гаргаж байсан бөгөөд тэр үед:

- 1.75 тэрбум төгрөгөөр
- 2.2 сая ширхэг хүртэлх хувьцаа эргүүлэн авах зорилт тавьж байжээ.

Хөрөнгө оруулагчдад ямар ач холбогдолтой вэ?

Buyback буюу хувьцаагаа эргүүлэн худалдан авах үйл ажиллагаа нь:


- Нийт эргэлтийн хувьцааны тоог бууруулах замаар хувьцааны үнэ цэнийг өсгөхөд нөлөөлж болдог.
- Хөрөнгө оруулагчдад эерэг дохио өгөх (компани өөрийн хувьцааг үнэ цэнтэй гэж үзэж байна гэсэн мессеж).
- Хас банкны энэ алхам нь зах зээлд өөртөө итгэлтэй байгаагийн илрэл хэмээн зарим шинжээчид тайлбарлаж байна.

ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн хэлбэлзэл (2015-2025)

| | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 | ДУНДАЖ |
|--------|--------|--------|--------|--------|--------|--------|---------|--------|--------|--------|-------|--------|
| 1 сар | -2.10% | -1.00% | 5.40% | -4.20% | 7.50% | 0.90% | 10.50% | 1.90% | 3.50% | 7.00% | 2.90% | 2.90% |
| 2 сар | -3.50% | -3.00% | -0.90% | -0.10% | -0.60% | -0.90% | 29.20% | -4.60% | 2.40% | 5.50% | 1.70% | 2.30% |
| 3 сар | -3.50% | -5.10% | 4.60% | -1.00% | -2.60% | -4.00% | 31.20% | -6.10% | 0.50% | 1.90% | | 1.60% |
| 4 сар | -3.00% | -1.50% | 2.50% | -4.60% | -3.70% | -8.70% | 4.10% | -0.90% | -5.20% | -3.30% | | -2.40% |
| 5 сар | -2.40% | -1.20% | -1.60% | -2.00% | 0.30% | -2.10% | 1.20% | -6.70% | 0.50% | -0.40% | | -1.40% |
| 6 сар | 13.90% | 5.20% | -1.60% | 0.90% | -1.80% | -1.00% | -7.70% | -3.70% | -0.60% | 0.80% | | 0.50% |
| 7 сар | -2.60% | 10.80% | 8.20% | -1.00% | 3.60% | 2.00% | -1.10% | -0.80% | 1.10% | 9.80% | | 3.00% |
| 8 сар | -6.70% | -1.80% | 8.70% | -0.90% | -2.80% | 1.60% | 7.70% | 4.60% | 0.00% | 3.50% | | 1.40% |
| 9 сар | -0.40% | -7.40% | 16.60% | 3.50% | -3.20% | 2.70% | 27.50% | -1.50% | -5.40% | -1.30% | | 3.10% |
| 10 сар | -0.60% | -2.70% | 16.90% | 2.10% | -3.60% | 1.60% | -10.00% | -1.90% | 0.60% | 0.20% | | 0.30% |
| 11 сар | -2.90% | -3.40% | 9.30% | -2.00% | 0.00% | 0.50% | -2.40% | 1.10% | 4.60% | 1.80% | | 0.70% |
| 12 сар | -3.60% | 7.00% | 0.10% | 0.10% | 1.90% | 3.30% | 5.80% | 5.40% | 5.00% | 2.00% | | 2.70% |

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2020)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

| Компанийн нэр | Симбол | Бүртгэх өдөр | Тараах өдөр | Нэгж хувьцаанд ногдох ашгийн хэмжээ | Нийт ногдол ашиг |
|---|--------|--------------|-----------------------------|---|--------------------|
|  ТАВАНТОЛГОЙ ХК | TTL | 2025.04.07 | 2025.05.01-ний өдрөөс эхлэн | 6960 | 366,549,792,000.00 |
|  MMX | MMX | 2025.04.07 | 2025.04.30 | 100 | 380,072,100 |
|  INNOVATION INVESTMENT | QPAY | 2025.04.08 | 2025-04-30-ны дотор | 20 | 3,697,783,200.00 |
|  "АРИГ ГАЛ" ХК | EER | 2025.04.10 | 2025-05-30-ны дотор | 100 | 338,933,100.00 |
|  ХАСBANK | XAC | 2025.04.10 | 7 хоногийн дотор | 27 | 28,422,900,000 |
|  ТӨРИЙН БАНК ХҮҮРИЙН ТӨС ХӨРӨНГӨ БАНК | SBM | 2025.04.10 | 2025/04/30-ны өдрийн дотор | 63.7 | 48,099,631,125 |
|  Bayangol Hotel | BNG | 2025.04.10 | 2025-05-01-ний дотор | 330 | 125,773,890 |
|  ТАНДАН ИМВЕСТЬ ЕБС ТӨСВИЙН ХӨРӨНГӨ | TAND | 2025.04.10 | 2025.04.30 | 1.1 | 2,200,000,000 |
|  TELECOM MONGOLIA | MCH | 2025.04.11 | 2025.06.02 | 1 | 98,365,240,00 |
|  BASALTWOOL МОНГОЛБАЗАЛТЫ ХК | MBW | 2025.04.11 | 2025-04-30-ны дотор | 2.42 | 136,529,140 |

МХБ-д бүртгэлтэй компаниудын ногдол ашгийн бүртгэлийн өдөр

- Дотоодын 46 хувьцаат компани 2024 оны цэвэр ашгаасаа нийт 1.04 их наяд төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэдээ тараахаар шийдвэрлэсэн билээ. Тэгвэл энэ 4-р сарыг 14 өдрийг хүртэл үргэлжлэх ногдол ашиг авах боломжтой хөрөнгө оруулагчдын хувьцааны бүртгэлийн өдрийг та бүхэнд хүргэж байна.
- T+2 төлбөр тооцооны горимын дагуу 2 хоногийн өмнө хувьцааг эзэмшсэн байх ёстой бөгөөд жишээ нь: Монложистик Холдинг ХК-ний ногдол ашгаас авахыг хүсвэл өнөөдөр хувьцааг нь худалдаж авч болох сүүлийн өдөр гэсэн үг юм.

T+2 төлбөрийн тооцооны системийн дагуу явдаг учир бүртгэлийн өдрөөс 2 өдрийн өмнөх эзэмшлээс тооцдог болохы анхаарна уу